



МИК ХОЛДИНГ ХК

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ

2021 оны 03 сарын 19 өдөр

№ 21/09

Улаанбаатар хот

Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал хуралдуулах тухай

Компанийн тухай хуулийн 59 дүгээр зүйлийн 59.4 дэх хэсэг, 60 дугаар зүйлийн 60.1, 60.2, 60.4 дэх хэсэг, 64 дүгээр зүйлийн 64.2 дахь хэсэг, 65 дугаар зүйлийн 65.1, 65.4 дэх хэсэг, 71 дүгээр зүйлийн 71.1, 71.3, 71.4 дэх хэсэг, 76 дугаар зүйлийн 76.1.2, 76.1.3 дахь заалт, Санхүүгийн Зохицуулах Хорооны 2018 оны 377 тоот тогтоолоор батлагдаж 2021 оны 45 дугаар тогтоолоор нэмэлт, өөрчлөлт оруулсан “Хувьцаат компанийн хувьцаа эзэмшигчдийн хурлын зар хүргэх журам”, Компанийн дүрмийн 8 дугаар зүйлийн 8.2 дахь хэсэг, 9 дүгээр зүйлийн 9.7.11, 9.7.12 дахь заалт, Төлөөлөн удирдах зөвлөлийн хурлын 2016 оны 16/22 дугаар тогтоолоор батлагдаж 2021 оны 21/08 дугаар тогтоолоор нэмэлт оруулсан “Хувьцаа эзэмшигчдийн хурал зарлан хуралдуулах тухай журам”-ыг тус тус үндэслэн **ТОГТООХ НЬ:**

1. Компанийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг 2021 оны 4 дүгээр сарын 29-ний өдрийн 11:00 цагт танхимаар, эсвэл компанийн боловсруулсан мэдээллийн технологи, программ хангамжийг ашиглан зайнаас цахим хэлбэрээр хуралдуулсугай.
2. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаар дараах асуудлыг хэлэлцүүлэхээр шийдвэрлэсүгэй. Үүнд:
 1. Компанийн 2020 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх ТУЗ-өөс гаргасан дүгнэлтийг хэлэлцэн батлах тухай;
 2. Ногдол ашиг хуваарилах эсэх талаар гаргасан ТУЗ-ийн шийдвэрийг танилцуулах тухай;
 3. ТУЗ-ийн 2020 оны үйл ажиллагааны тайланг танилцуулах тухай;
 4. Компанийн дүрэмд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай;
 5. ТУЗ-ийн гишүүдийг сонгох тухай;
 6. ТУЗ-ийн гишүүдийн цалингийн зардлын төсвийг батлах тухай.
3. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хуралд оролцох эрхтэй хувьцаа эзэмшигчдийн нэрсийн жагсаалт гаргах бүртгэлийн өдрийг 2021 оны 4 дүгээр сарын 12-ны өдрөөр тогтоосугай.
4. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал зохион байгуулах комиссыг дараах бүрэлдэхүүнтэйгээр томилсугай. Үүнд:

Комиссын дарга:	Г.Саруул, ТУЗ-ийн нарийн бичгийн дарга;
Гишүүн:	О.Чимэдрагчаа, “МИК ОССК” ХХК-ийн Олон нийттэй харилцах хэлтсийн захирлын үүрэг гүйцэтгэгч;
	Х.Маралмаа, ТУЗ-ийн ажлын албаны хуульч;
	Б.Оюунболд, “МИК ОССК” ХХК-ийн Мэдээллийн технологийн хэлтсийн захирлын үүрэг гүйцэтгэгч.
5. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын мэдэгдлийг хурлыг цахим хэлбэрээр зохион байгуулахтай холбоотой мэдээллийн хамт 2021 оны 3 дугаар сарын 22-ны өдөр Санхүүгийн Зохицуулах Хороо болон “Монголын Хөрөнгийн Бирж” ТӨХК-д тус тус хүргүүлэхийг хурал зохион байгуулах комисс (Г.Саруул)-т даалгасугай.
6. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал хуралдуулах тухай зарыг Хавсралт 1-р баталж, 2021 оны 3 дугаар сарын 24-ний өдөр болон мөн оны 4 дүгээр сарын 08-ны өдөр тус тус хоёроос доошгүй өдөр тутмын сонин, компанийн цахим хуудсаар дамжуулан хувьцаа эзэмшигчдэд мэдээлэхийг Хурал зохион байгуулах комисс (Г.Саруул)-т даалгасугай.
7. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаар хэлэлцэх асуудалтай холбоотой танилцаж болох баримт бичгийн жагсаалтыг Хавсралт 2-р баталж, энэхүү баримт бичгийг 2021 оны 3 дугаар сарын 29-ний өдөрт багтаан хувьцаа эзэмшигчдэд тэдгээрийн бүртгэлтэй үнэт цаасны

компаниудаар дамжуулан хэвлэмэл болон цахим хэлбэрээр хүргүүлж, танилцах бололцоогоор хангаж ажиллахыг Хурал зохион байгуулах комисс (Г.Саруул)-т даалгасугай.

8. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын даргаар Төлөөлөн удирдах зөвлөлийн дарга М.Мөнхбаатарыг томилсугай.

9. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын Тооллогын комиссыг дараах бүрэлдэхүүнтэйгээр томилсугай. Үүнд:

Комиссын дарга: С.Амарсайхан, “МИК ОССК” ХХК-ийн Эрсдэлийн удирдлагын газрын захирал;

Гишүүн: Б.Болортуяа, “МИК ОССК” ХХК-ийн Хууль, эрх зүйн газрын захирал;

Гишүүн: Ц.Мандах, “МИК ОССК” ХХК-ийн Судалгаа, хөгжүүлэлтийн хэлтийн захирал;

Гишүүн: Б.Солонго, “МИК ОССК” ХХК-ийн Хянан нийцүүлэлтийн газрын нийцэл хариуцсан ахлах мэргэжилтэн.

10. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаас гарах шийдвэрийн төсөлд хувьцаа эзэмшигчдээс саналын хуудсаар санал авч, түүнийг үндэслэн хурлын тогтоолыг гаргахыг хурлын дарга (М.Мөнхбаатар)-д даалгасугай.

11. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын дэгийг Хавсралт 3-р, санал хураалтаар шийдвэрлэх асуудал бүрээр “Санал авах хуудас”-ны загварыг Хавсралт 4, 5, 6, 7-р тус тус баталсугай.

12. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын саналын хуудсыг хувьцаа эзэмшигчдэд тэдгээрийн бүртгэлтэй үнэт цаасны компаниудаар дамжуулан хүргүүлэхийг Хурал зохион байгуулах комисс (Г.Саруул)-т, хурлаар шийдвэрлэх асуудалд өгсөн саналыг хурлын мэдэгдэл гаргасан өдрөөс эхлэн 2021 оны 4 дүгээр сарын 28-ны өдрийн 17:00 цаг хүртэл хүлээн авах, түүнтэй холбоотой бусад арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг Тооллогын комисс (С.Амарсайхан)-т тус тус үүрэг болгосугай.

13. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал хуралдуулахтай холбоотой зардлыг санхүүжүүлэхийг Гүйцэтгэх захирал (Б.Гантулга)-д даалгасугай.

14. Энэ тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг ТУЗ-ийн дэргэдэх Нэр дэвшүүлэх, шагнал урамшууллын хороо (М.Мөнхбаатар)-нд үүрэг болгосугай.

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ
ЗӨВЛӨЛИЙН ДАРГА



М.МӨНХБААТАР